

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/230/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/230/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.19 № 35

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас “Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийн хүрээнд 1,480,813.0 мянган төгрөгийн санхүүжилтийг боловсролын байгууллага, багш, сурагчдад урамшуулал хэлбэрээр олгосон байна.

“Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийн үр дүнгээр аймгийн сургууль, цэцэрлэгийн сурлагын амжилт, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр улсын дунджаас дээгүүр үнэлэгдэж улсад 5 дугаар байрт, элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр 9 дүгээр байрт шалгарсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 199,083.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 28,760.9 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2 зорилт, 95 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 90 арга хэмжээг бүрэн, 3 арга хэмжээг 90 хувь, 2 арга хэмжээг 70 хувь буюу нийт дүнгээр 99 хувиар үнэлэгдсэн байна.

07020162

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	61,402.7	113,289.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,151,418.7	1,294,601.5
Нийт хөрөнгийн дүн	1,212,821.4	1,407,890.8
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,212,821.4	1,407,890.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,212,821.4	1,407,890.8
Үйл ажиллагааны орлогын дүн	4,368,049.2	5,285,383.5
Үйл ажиллагааны зардлын дүн	4,123,951.6	5,090,314.0
Үйл ажиллагааны үр дүн	244,097.6	195,069.5
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	244,097.6	195,069.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	1,212,821.38	1,212,821.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	968,723.8	1,212,821.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Тайлант оны үр дүн	244,097.6	195,069.5
Эцсийн үлдэгдэл	1,212,821.4	1,407,890.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,898,974.6	5,024,642.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,888,124.6	5,004,642.0
Үйл ажиллагааны ЦМГ	10,850.0	20,000.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(10,850.0)	(20,000.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,891,864.1	3,167,168.1
Урсгал зардал	2,891,864.1	3,167,168.1
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,891,864.1	3,167,168.1
Улсын төсвөөс санхүүжих	2,891,864.1	3,167,168.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 2,138.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 1,792.5 мянган төгрөгийг нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.
- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 320.0 мянган төгрөгөөр, орлогын дүн 26.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 9,237.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9,237.5 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрч 4,675.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,562.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээнээс илүү 835.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалыг ажилчдад олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" (Энэ заалтад Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын амралтын цалин давхардуулан олгосон мөнгийг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын нягтлан бодогч, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн нарт давхардуулан 3,840.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-т "Хуулиар зөвшөөрөөгүй бусад" Боловсрол, шинжлэх ухааны яамны 2023 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2/3151 дугаартай албан бичиг"-т заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Балансын урамшуулалд давхардуулан олгосон мөнгийг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр нягтлан бодогчийн үндсэн цалин нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2-т "Салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг харгалзан үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй", Засгийн газрын 2023 оны 241-р тогтоолын 2-т " Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн шийдвэрийг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчийн төрд ажилласан жилийг буруу тооцож 3 хүнд 2,970.0 мянган төгрөгийн дутуу, цалингийн дундаж буруу тооцож 4 хүнд 1,592.0 мянган төгрөгийг илүү тэтгэмж олгосон нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох" журмын 3.1-т "Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулж тооцно: 3.1.4-т "Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтан (хөлсөөр түр ажиллагч орохгүй)-аар 1996 оны 8 дугаар сарын 1-ны өдрөөс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа; (Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон) 3.1.6-т "Төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний болон амаржсаны амралттай, хууль тогтоомжийн дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацаа; 3.1.12-т "Нийгмийн шилжилтийн явцад ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний 1990-1995 оны хооронд ажилласан жил тасарсан иргэнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас зохих журмын дагуу олгосон баталгаажилтын хуудсыг үндэслэн ажилласнаар нөхөн тооцуулсан хугацаа" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн дагуу тэтгэмжийг тооцон олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн санхүүжилтээр багш, сурагчдад мөнгөн урамшуулал олгосон боловч гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байгаа

нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөр арга, хэмжээний санхүүжилтийг олгохдоо нотлох баримтын чадамжийг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Боловсрол шинжлэх ухааны газар	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 320.0 мянган төгрөгөөр, орлогын дүн 26.0 мянган төгрөгөөр зерүүтэй тайлагнасан.	1	346.0	-	-	1	346.0	1	346.0	-	-	-	-
	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 1,792.5 мянган төгрөгийн гүйлгээ байна	1	1,792.5	1	1,792.5	-	-	-	1,792.5	-	-	-	-
Дүн		2	2,138.5	1	1,792.5	1	346.0	1	2,138.5	-	-	-	-

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:													
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн							
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12						
	Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээнээс илүү 835.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалтыг ажилчдад олгосон	1	835.5	1	835.5	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Байгууллагын нягтлан бодогч, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн нарт давхардуулан 3,840.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон.	1	3,840.0	1	3,840.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Боловсрол шинжлэх ухааны газар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр нягтлан бодогчийн үндсэн цалин нэмэгдүүлсэн.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчийн төрд ажилласан жилийг буруу тооцож 3 хүнд 2,970.0 мянган төгрөгийн дутуу, цалингийн дундаж буруу тооцож 4 хүнд 1,592.0 мянган төгрөгийг илүү тэтгэмж олгосон.	1	4,562.0	-	-	1	4,562.0	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн санхүүжилтээр багш, сурагчдад мөнгөн урамшуулал олгосон боловч гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт		5	9,237.5	1	4,675.5	2	4,562.0	1	-	-	-	-	-	-	-	-	-

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/Мянган төгрөгөөр/

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Боловсрол шинжлэх ухааны газар	Тайлант онд 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна Хөдөө орон нутгийн тэтгэмж олгохдоо 32 албан хаагчид 1-2 жилийн хугацаагаар хоцроож олгосон байна.	1	20,000.0	-	-	1	20,000.0	-	-	-	-		
Нийт		2	20,000.0	-	-	1	20,000.0	1	-	-	-		